



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

## ОЙН ГАЗАР

Төрийн өмчийн II байр, Чингүнжавын гудамж,  
6 дугаар хороо, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16050  
Утас: 7711 1180, Факс: (976-11) 30 00 78,  
Цахим шуудан: info@forest.gov.mn

2024.04.17 № 01/228  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

## ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖТАЙ АГААРЫН ХӨЛӨГ АШИГЛАН ТЭМЦЭХ ОйГ/20240101108 ДУГААРТАЙ ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

### Тодруулга хүргүүлэх тухай

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн "Ойжуулалт хөтөлбөрийн 2024 онд үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлах тухай" А/10 дугаар тушаал нь "ОЙЖУУЛАЛТ" хөтөлбөрийн төлөвлөгөө батлах тухай тушаал юм. Энэхүү тушаалын хавсралтад ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлын төлөвлөгөө, төсвийг баталсан бөгөөд ОйГ/20240201004 дугаартай тендер шалгаруулалттай холбоотой ямар нэгэн заалт ороогүй болно.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар нь 2024 оны 03 дугаар сарын 7-ны өдөр ОйГ/20240101107, ОйГ/20240101108, ОйГ/20240201004 дугаартай бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй бөгөөд ойн хөнөөлт шавжтай тэмцэх "АЖИЛ"-ын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажиллагааг 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдөр ОйГ/20240101107, ОйГ/20240101108 дугаартайгаар нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулж байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн "Ойжуулалт хөтөлбөрийн 2024 онд үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлах тухай" А/10 дугаар тушаалын дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/18 тоот тушаалаар баталсан.

Гэвч сүүлийн жилүүд буюу 2022, 2023 онд хийгдсэн ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлын үр дүн стандартын шаардлагыг дөнгөж хангах төдий байгаагаас шалтгаалан ойн сан хөнөөлт шавжийн нөлөөгөөр хатаж хуурайшин доройтолд орж байна. Үүний шалтгаан нь авиа микробиологийн аргаар агаарын хөлөг болон үүргийн шүршигч багаж ашиглан тэмцэх ажлыг гүйцэтгэгч аж ахуйн нэгж, тэмцлийн ажилд ашиглаж буй бэлдмэл бодисын чанар үйлчилгээний аль шатанд алдаа гарч буйг бүрэн хянах, үнэлж тодорхойлох боломжгүй, аль тал нь зөрчил дутагдал гаргасан нь тодорхой бус байгаагаас шалтгаалж байна гэж захиалагч үзсэний улмаас Ойн газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/18 тоот тушаалаар батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр "Байгууллагын 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн батлах тухай" А/37 тоот тушаалыг баталж, энэхүү тушаалын дагуу худалдан авах ажиллагааг зарлаад байна.

Худалдан авах ажиллагааны шинэчилсэн төлөвлөгөөний дагуу ойн хөнөөлт шавжтай агаарын хөлөг болон үүргийн шүршигч багаж ашиглан микробиологийн аргаар тэмцэх ажлын гүйцэтгэгч нь агаарын хөлгөөр үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байгууллага, бэлдмэл бодис нийлүүлэх эрх бүхий байгууллагатай "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтын дагуу түншлэлээр оролцох бүрэн боломжтойгоор худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.



“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 4.1.1 дэх хэсэгт “ажил” гэж барилга байгууламж, инженерийн дэд бүтцийг барих, засварлах, өргөтгөх, буулгах, шинэчлэх, геологийн судалгаа хийх болон тэдгээрт холбогдох тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, турших, тохируулах зорилгоор хүн хүч, машин техник, тоног төхөөрөмж, материал, технологийг хослуулан ашиглаж гүйцэтгэх ажлыг болон түүнийг дагалдан нийлүүлэх барааг гэж тодорхойлсны дагуу “АЖИЛ” гүйцэтгэх худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгаа нь холбогдох хуулийг зөрчөөгүй болно.


Ойн хөнөөлт шавжтай үүргийн шүршигч багаж ашиглан тэмцэх ОГ/20240101107 тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолтод *Bacillus thuringiensis var kurstaki* болон *dakota* эсхүл түүнтэй дүйцэх, Лепидоцид СК эсхүл түүнтэй дүйцэх био бэлдмэл, *Bacillus thuringiensis Bt-MN01* эсхүл түүнтэй дүйцэх стандартын шаардлага хангасан био бэлдмэлийг тэмцлийн ажилд хэрэглэхээр зааж тусгасан.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 8.2 дах хэсэгт энэ хуулийн 8.1-д заасан барааны нэр, төрлийн жагсаалтыг эдийн засаг, хөгжлийн, хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран боловсруулж, Засгийн газар батална гэж заасан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалтын 8 дугаар зүйлийн 8.1.1-д “ургамал хамгааллын бодис” гэж заасныг захиалагч тендерийн баримт бичиг боловсруулахдаа тусгаагүй нь хууль бус болсон байна гэж гомдол ирүүлсэн нь тус газраас зарласан “АЖИЛ” гүйцэтгэх худалдан авах ажиллагаанд хамааралгүй болно.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 11.4 дэх хэсэгт захиалагч шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлэх доор дурдсан үндсэн шалгуурын аль нэгийг сонгон тендер шалгаруулалтын баримт бичигт заана, 11.4.3 дэх хэсэгт чанар ба үнийн хосолмол аргыг хэрэглэж болно гэж заасан бөгөөд тус хуулийн 11.8 дэх хэсэгт чанар ба үнийн хосолмол үнэлгээний шалгуурыг зөвхөн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахад хэрэглэнэ гэж заасан тул гомдол үндэслэлгүй байна.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт бараа худалдан авах тендер шалгаруулалт зохион байгуулахад энэ хуулийн 8.2-т заасан барааг бусад бараанаас тусад нь багцална гэсэн заасан нь тус газрын зарласан “АЖИЛ” гүйцэтгэх тендер шалгаруулалттай хамааралгүй байна. Ойн хөнөөлт шавжтай үүргийн шүршигч багаж ашиглан тэмцэх ОйГ/20240101107 дугаартай ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтыг худалдан авах ажиллагааны нээлттэй тендер шалгаруулалтын журмын харьцуулах үнийн аргаар зохион байгуулан ажиллаж байна.

ДАРГА



Б.ОЮУНСАНАА